*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

Мэдээллийн төвийн *(нэгжийн нэр) ахлах ажилтан бөгөөд Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч (албан тушаалын нэр)*
В.Цэндхүү *(албан хаагчийн овог, нэр)*-н
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “ ............................................................................................”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1<br>Төрийн байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангах хүрээнд үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг бэлтгэн олон нийтэд хүргэх. | Мэдээлэл бэлтгэсэн /тоо/<br><br>Хандалт /тоо/ | **1000** гаруй текст мэдээ, мөн тооны фото мэдээ, **500** гаруй постер, **750** гаруй видео мэдээ нийтэлсэн байна. бэлтгэн хүргэсэн нэг мэдээ мэдээлэл дунджаар 8000 иргэнд хүрсэн байна. | Гүйцэтгэлээр | 1. Аймгийн Засаг даргын 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, 2024 оны хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил болон ЗДТГ-аас хийж хэрэгжүүлж буй ажлууд, түүний харьяа хэлтэс агентлагуудаас зохион байгуулсан онцлох ажил, орон нутгийн болон улсын чанартай хурал зөвлөгөөн, тэмцээн уралдааны мэдээ, сурвалжилга, олон нийтийг хамарсан үйл ажиллагааны мэдээллийг тухай бүрт нь бэлтгэн ажиллалаа.<br>Жилийн эцсийн байдлаар www.erdenet.mn мэдээллийн сайтад 1000 гаруй текстэн мэдээ Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын пэйж хуудас, аймгийн Засаг даргын пэйж хуудаст мөн тооны фото болон видео мэдээллийг бэлтгэсэн байна.<br>Үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын 500 гаруй постер мэдээллийг бэлтгэлээ.<br>2. Тайлант хугацаанд Статистикийн хэлтэс, Онцгой байдлын газар, | 2024 оны 1 сар | 2024 оны 12 сар |

55

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | БШУГ, Замын цагдаа, Эрдэнэт ус, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц зэрэг байгууллагуудаас цаг үеийн асуудлаар зарласан хэвлэлийн хурал мөн Хүүхдийн баяр, улсын баяр наадам зэрэг томоохон үйл ажиллагааны талаар иргэд олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой 30 удаагийн хэвлэлийн хурлын зарыг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад түгээж, ХМБ-ыг зохион байгуулж, мэдээллийг бэлтгэн ажиллалаа.<br>Пэйжийн хандалт долоо хоногт дунджаар 50 мянган үзэлттэй байна. Нэг мэдээлэл дунджаар 5000-8000 хүнд хүрч байна. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2.<br>Байгууллагын вэб сайтын мэдээ мэдээллийн булан болон цахим хуудасны үйл ажиллагааг жигд тасралтгүй явуулах. | Мэдээлэл бэлтгэсэн /тоо/<br><br>Хандалт /тоо/ | **1000** гаруй текст мэдээ, мөн тооны фото мэдээ, **500** гаруй постер, **750** гаруй видео мэдээ нийтэлсэн байна. бэлтгэн хүргэсэн нэг мэдээ мэдээлэл дунджаар 8000 иргэнд хүрсэн байна. | Гүйцэтгэлээр | www.erdenet.mn орон нутгийн албан ёсны вэб сайт, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын Пэйж хуудаст 1000 гаруй текст болон фото мэдээллийг бэлтгэн нийтэлжээ. Нэг үйл явдлаас фото болон текст, видео мэдээлийг хамтад нь 3 төрлөөр бэлтгэн ажиллаж хэвшээд байна.<br>Пэйжийн хандалт долоо хоногт дунджаар 50 мянган үзэлттэй байна.<br>Цахим хуудас болон байгууллагын вэб сайтын тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор үйл явдлын мэдээ мэдээллээс гадна хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлууд, онцлох ажлын мэдээ мэдээллийг бэлтгэн хүргэж байна. Өдөрт дунджаар 1-3 мэдээ мэдээлэл тогтмол орж хэвшсэн. | 2024 оны 1 сар | 2024 оны 12 сар |
| 3. | Арга хэмжээ 1.3<br>Орон нутгийн ХМБ-дад аймгийн Засаг дарга түүний Тамгын газраас зохион байгуулж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэх. | Мэдээлэл бэлтгэсэн /тоо/<br><br>ХМБ-аар мэдээлэл | 2023 онд давхардсан тоогоор 60 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагатай | Гүйцэтгэлээр | Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад аймгийн Засаг дарга түүний Тамгын газраас зохион байгуулж буй үйл ажиллагааны зар, мэдээллийг тухайн бүрт нь хүргэн ажиллаж байна. Эдгээрт орон нутгийн онцлох ажил, хөрөнгө оруулалт | 2024 оны 1 сар | 2024 оны 12 сар |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | түгээсэн /тоо/ | хамтран ажилласан байна. | | бүтээн байгуулалт, үйл явдлыг тухайн бүр хүргэж улсын хэмжээнд тогтмол түгээн ажиллалаа. Орон нутгийн ХМБ-ууд нь 7 хоногт дунджаар орон нутгийн Засаг захиргаанаас хийж хэрэгжүүлж буй ажлын талаарх 15 - 20 мэдээ бэлтгэн иргэдийг мэдээллээр хангах үүргээ биелүүлж байна.<br>Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээ мэдээлэл хүргэхдээ сэтгүүлчдийн групп чатыг ашиглан нэгэн зэрэг мэдээлэл хүргэдэг. | | |
| 4. | Арга хэмжээ 1.4<br>Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил, үйл ажиллагааны талаарх видео бичлэг, гэрэл зургийн архив бүрдүүлж хадгалах. | Бүрдүүлсэн материалын багтаамж /тоо/<br><br>Дуу дүрсний нягтаршил /хувь чанар/ | 2023 онд 2023 оны ажлын архив нийт 3.13 ТВ /3.449 bytes/- ын багтаамжтай, видео, гэрэл зураг болон контентууд архивласан байна. | Гүйцэтгэлээр | 2024 онд зохион байгуулсан орон нутаг, улсын чанартай томоохон хурал зөвлөгөөн, тэмцээн уралдаан болон өдөр тутамд болж буй үйл явдлын мэдээллийн зураг, бичлэгийг холбогдох газар, хэлтэс агентлагуудад хэвлэл, эх бэлтгэл, дуу, дүрсний 100 хувь чанарын төвшинд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.<br>Тайлант хугацаанд 300 орчим үйл явдал, арга хэмжээний фото зураг мөн тооны дүрс бичлэгийг дүү, дүрсний өндөр чанартайгаар архивлаад байна. Өнөөдрийн байдлаар 3ТВ гаран хэмжээтэй файл үүссэн байна. | 2024 оны 1 сар | 2024 оны 12 сар |
| 5. | Арга хэмжээ 1.5<br>Аймгийн ЗДТГ-ын харьяа хэлтэс агентлагуудад хэвлэл мэдээлэл, гэрэл зураг, эх бэлтгэлийн чиглэлээр дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах. | Хамтран ажилласан тоо<br><br>Дуу дүрсний эх бэлтгэлийн чанар | 2023 онд аймгийн хэмжээнд зохион байгуулсан томоохон хэлэлцүүлэг, форум, уулзалт хурал цуглаан, тэмцээн уралдаан зэрэг 10 гаран үйл явдлын архив үүсгэсэн. | Гүйцэтгэлээр | Манай аймагт зохион байгуулсан**улсын аварга шалгаруулах** Жүдо, чөлөөт бөх, таеквандо, монгол хэл бичгийн олимпиад, тогооч нарын тэмцээн уралдаан, аймгийн Засаг даргын нэрэмжит Заан цолтнуудад хүндэтгэл үзүүлэх барилдаан, Илгээлтийн эздийн 50 жилийн ойн бэлтгэл ажил, зохион байгуулалт, мэдээ сурвалжилгыг орон нутгийн болон төвийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран бэлтгэж, мэдээллийг түгээн ажиллалаа. Мөн улсын хэмжээний томоохон хурал зөвлөгөөний бэлтгэл, зохион байгуулалт хангахын зэрэгцээ мэдээ, сурвалжилгыг бэлтгэн ажиллалаа. Тухайлбал: Эрдэнэт шинэ илгээлт үйл ажиллагаа, Шинэ хоршоо хөдөлгөөн, Барилгын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн зэрэг үйл ажиллагааны | 2024 оны 1 сар | 2024 оны 12 сар |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээ, сурвалжилгыг бэлтгэж төвийн хамтран ажилладаг хэвлэлүүдэд мэдээ бэлтгэн түгээлээ. Нийт 15 гаруй томоохон хурал зөвлөгөөн уулзалт хэлэлцүүлгийн хэвлэл сурталчилгааны ажлыг Мэдээллийн төв зохион байгуулан ажиллалаа. | | |
| 6. | Арга хэмжээ 1.6<br>Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлж, мэдээ мэдээллээр хангах. | Үүрэг даалгаврыг биелүүлсэн гүйцэтгэлийн чанар<br><br>Үүрэг даалгаврын биелүүлсэн байдал /тоо/ | Удирдлагуудаас өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлж, гүйцэтгэлийг тухай бүр танилцуулан ажиллав. | Гүйцэтгэлээр | Аймгийн Засаг даргаас болон удирдлагуудаас ирүүлсэн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж эргэж мэдээллэх зарчмаар ажиллаж байна. Түүнчлэн салбарын холбогдолтой асуудлуудыг тухай бүр танилцуулан ажиллаж байна. И-Оффис программаар нийт 19 үүрэг даалгавар иржээ. | 2024 оны 1 сар | 2024 оны 12 сар |
| 7. | Арга хэмжээ 1.7<br>Улсын болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах, тэднийг мэдээ мэдээллээр хангах. | Төрийн байгууллагын мэдээ мэдээллийг ХМБ-дад түгээн ажилласан /тоо/<br><br>Хамтран ажилласан ХМБ-ын /тоо/ | 2023 онд орон нутгийн 20 ХМБ, төвийн 9 ХМБ-тай хамтран ажилласан. | Гүйцэтгэлээр | Давхардсан тоогоор 2024 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн болон төвийн 50 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулав. Орон нутгийн онцлох хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөр, зэрэг төрийн байгууллагаас бэлтгэсэн мэдээ мэдээллийг МҮОНТВ, UBS ТВ, gogo.mn, news.mn, zogii.mn, zarig.mn, зэрэг төвийн 10 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагуудад жилийн турш түгээн ажиллалаа. Мөн давхардсан тоогоор орон нутгийн 20 гаруй ХМБ-тай хамтран ажиллаж тэдэнд мэдээ мэдэллийг түгээн ажиллаж байна. | 2024 оны 1 сар | 2024 оны 12 сар |
| 8. | Арга хэмжээ 1.8<br>Аймгийн Засаг даргын үйл ажиллагаа, үндсэн чиглэлийн биелэлтийг сурталчлах тайлангийн контент бэлтгэн олон нийтэд хүргэх. | Бэлтгэсэн тайлангийн контентын тоо<br><br>Чанар /хувь/<br><br>Хандалт /тоо/ | 2023 онд тайлангийн видео 3, сэтгүүл 1, сонин 2 хийж гүйцэтгэсэн. | Гүйцэтгэлээр | Тайлант хугацаанд 2020- 2024 оны онцлох 30 ажлын мэдээллийг /постер, рийл, видео болон текст мэдээлэл/ цувралаар бэлтгэн хүргэлээ.<br>Түүнчлэн 4 жилийн онцлох ажлыг эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц, дахин төлөвлөлт, соёл урлаг, ХБИ зэрэг салбар тус бүрээр нь гаргаж бэлтгэн бэлэн болгосон. Мөн энэ оны хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын гол ажил болох авто зам | 2024 оны 1 сар | 2024 оны 12 сар |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинэчлэлийн ажлын мэдээ мэдээлэл, контентыг тухай бүрт бэлтгэн иргэд олон нийтэд хүртээмжтэй байдлаар хүргэн ажиллалаа.<br>Тайлант хугацаанд тайлангийн танилцуулгын 1 сэтгүүл, 2 нэвтрүүлэг бэлтгэжээ. | | |
| **Зорилт 2. “ ..............................................................................................”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1.<br>Салбарын холбогдолтой шинээр гарсан хууль тогтоомж, шийдвэрүүдтэй танилцаж, ажилдаа хэрэгжүүлэн ажиллах | | | | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон УИХ-д өргөн бариад буй Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг судалж байна. | 2024 оны 1 сар | 2024 оны 12 сар |
| | | | | | | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Мэдээллийн төвийн ахлах ажилтан ............................... / В.Цэндхүү / 2024. 12. 15

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

/16/